



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/512

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2022 оны 10 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын хөрөнгөөр худалдан авсан Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн вакцинаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 1-5 насны хүүхэд болон эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн ажилтныг вакцинжуулах ажлыг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /С.Өнөрсайхан/-д, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Б.Билэгтсайхан/-д, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Улирлын томуугийн эсрэг “GCFLU” вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, БНСУ-ын Грийнкросс үйлдвэрийн улирлын томуугийн эсрэг “GCFLU” вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар, Улирлын томуугийн вакцинжуулалтын хамралтын мэдээний маягыг гуравдугаар, Улирлын томуугийн вакцин хийхэд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас авах зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Хуваарилсан вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөөр бүртгэн, зарцуулалтанд нь хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Б.Билэгтсайхан/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т даалгасугай.

САЙД *С. Энхболд* /С.ЭНХБОЛД

141222389

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 сарын 19-ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улирлын томуугийн эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн хуваарь

1. АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Д/д	Аймаг	Вакцинд хамруулах зорилтот бүлэг				Шаардлагатай вакцин, тариур	
		1-5 хүртэлх насны хүүхдүүд	Жирэмсэн эмэгтэйчүүд	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүс/	Олгох хүн тун	Тариур 1 мл
		70%	50%				
1	Архангай	5,850	980	940	5,000	12,770	12,770
2	Баян-Өлгий	7,950	1,550	1,060	5,000	15,560	15,560
3	Баянхонгор	5,870	1,100	1,190	5,000	13,160	13,160
4	Булган	3,500	550	710	5,000	9,760	9,760
5	Говь-Алтай	3,420	750	880	5,000	10,050	10,050
6	Говьсүмбэр	1,260	390	200	3,000	4,850	4,850
7	Дархан-Уул	6,610	1,290	790	5,000	13,690	13,690
8	Дорноговь	4,390	920	750	5,000	11,060	11,060
9	Дорнод	5,700	1,150	950	5,000	12,800	12,800
10	Дундговь	3,040	610	690	5,000	9,340	9,340
11	Завхан	4,310	800	990	5,000	11,100	11,100
12	Орхон	6,650	1,400	700	5,000	13,750	13,750
13	Өвөрхангай	7,300	1,280	1,080	5,000	14,660	14,660
14	Өмнөговь	4,900	1,030	690	5,000	11,620	11,620
15	Сүхбаатар	4,260	910	710	5,000	10,880	10,880
16	Сэлэнгэ	6,450	1,030	1,130	5,000	13,610	13,610
17	Төв	5,780	720	1,310	5,000	12,810	12,810
18	Увс	5,680	1,050	900	5,000	12,630	12,630
19	Ховд	6,120	1,150	1,000	5,000	13,270	13,270
20	Хөвсгөл	8,340	1,520	1,130	5,000	15,990	15,990
21	Хэнтий	4,980	1,000	920	5,000	11,900	11,900
Нийт		112,360	21,180	18,720	103,000	255,260	255,260

2. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Д/Д	Дүүрэг	Вакцин (хүн тун)				Шаардлагатай вакцин, тариур	
		Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	1-5 хүртэлх насны ХҮҮХДҮҮД	Жирэмсэн эмэгтэйдүүд	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүс/	Олгох хүн тун	Тариур 1 мл
1	Сүхбаатар ЭМТ	660	8,790	1,600	15,000	26,050	26,050
2	Баянгол ЭМТ	670	15,680	2,600	15,000	33,950	33,950
3	Баянзүрх ЭМТ	1130	25,650	6,000	25,000	57,780	57,780
4	Чингэлтэй ЭМТ	580	9,340	2,600	15,000	27,520	27,520
5	Сонгинохайрхан ЭМТ	1000	22,900	4,400	25,000	53,300	53,300
6	Хан-Уул ЭМТ	880	14,970	2,000	10,000	27,850	27,850
7	Налайх ЭМТ	400	2,370	680	5,000	8,450	8,450
8	Багануур ЭМТ	380	1,700	1,000	5,000	8,080	8,080
9	Багахангай ЭМТ	30	300	160	720	1,210	1,210
10	Нийслэлийн яаралтай тусламжийн төв	400				400	400
11	Нийслэлийн шүд эрүү нүүрний эмгэгийн төв	50				50	50
12	Нийслэлийн эрүүл мэндийн газар	60				60	60
13	Хүүхдийн сэргээн засах бяцхан тэмүүлэл төв	40				40	40
Нийт		6,280	101,700	21,040	115,720	244,740	244,740

Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах улирлын
томуугийн эсрэг вакцины хуваарь
/ Эрүүл мэндийн байгууллага,бусад салбарын байгууллага /

Д/д	Бусад эрүүл мэндийн байгууллага	Олгох хүн тун	Тариур 1 мл (ширхэг)
1	Эрүүл мэндийн яам	100	100
2	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	500	500
3	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	800	800
4	Улсын гуравдугаар төв эмнэлэг	500	500
5	Халдварт өвчин судлалын үндэсний төв	750	750
6	Хавдар судлалын үндэсний төв	560	560
7	Зооноз өвчин судлалын үндэсний төв	90	90
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	1,000	1,000
9	Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв II	400	400
10	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	400	400
11	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	150	150
12	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	250	250
13	Төрийн тусгай албан хаагчдийн нэгдсэн эмнэлэг	300	300
14	Цэргийн төв эмнэлэг	500	500
15	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	100	100
16	Гэмтэл согог судлалын үндэсний төв	300	300
17	Арьсны өвчин судлалын үндэсний төв	120	120
18	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	400	400
19	Хөдөлмөр аюулгүй байдлын эрүүл мэндийн төв	40	40
20	Геронтологийн үндэсний төв	40	40
21	Эрүүл мэндийн хөгжлийн төв	40	40
22	Хүүхдийн төв сувилал	100	100
23	Төмөр замын нэгдсэн эмнэлэг	200	200
24	Монгол-Японы эмнэлэг	500	500
25	АШУҮИСургууль	1,000	1,000
29	Энэрэл эмнэлэг	90	90
30	429-р хорих анги эмнэлэг	70	70
31	401-р хорих анги эмнэлэг	100	100
32	Уламжлалт Анагаах ухаан технологийн хүрээлэн	100	100
Нийт		9,500	9,500

Д/д	Бусад байгууллага	Олгох хүн тун	Тариур 1 мл (ширхэг)
1	Улсын Их Хурлын тамгын газар	300	300
2	Онцгой байдлын ерөнхий газар	2,500	2,500
3	Хил хамгаалах ерөнхий газар	2,400	2,400
4	Зэвсэгт хүчин, жанжин штаб	2,400	2,400
5	Тагнуулын ерөнхий газар	1,300	1,300
6	Цагдаагийн ерөнхий газар	2,400	2,400
7	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,000	2,000
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	750	750
9	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	200	200
10	Төрийн тусгай хамгаалалтын алба	600	600
11	Үндсэн хуулийн цэц	50	50
12	Дотоод хэргийн их сургууль	500	500
13	Чингис хаан олон улсын буудал дахь Гаалийн газар	100	100
14	Сайн дурын дархлаажуулалтын кабинет	20,000	20,000
	Нийт	35,500	35,500

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/с/д дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БНСУ-ЫН ГРИЙН КРОСС ҮЙЛДВЭРИЙН УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ "GCFLU Quadrivalent" ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Улирлын томуугийн эсрэг "GCFLU Quadrivalent" дөрвөн цэнт вакцин нь 2022/2023 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн вирусийн эсрэгтөрөгчийг идэвхгүйжүүлж гаргаж авсан, ДЭМБ-ын итгэмжлэл авсан вакцин юм.

Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дөрвөн дэд хэвшинжээр үүсгэгдсэн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Найрлага:

Нэг тун (0.5мл) томуугийн вирусийн дөрвөн цэнт вакцинд агуулагдах найрлага:

Идэвхтэй хэсэг: Томуугийн вирусийн цэвэршүүлж, идэвхгүйжүүлсэн антиген.....60µg
А хүрээний Victoria/2570/2019 IVR-215(H1N1).....15µg
А хүрээний Darwin/9/2021 SAN-010(H3N2)15µg
В хүрээний /Austria/1359417/2021 BVR-26.....15µg
В хүрээний /Phuket/3073/2013.....15µg

Нэмэлтээр натри, калийн хлорид, гидрофосфат натри, калийн дигидроген фосфат, тарилгын ус агуулна.

Савлагаа:

Нэг хүн тун нь 0.5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Өнгөгүй, шингэн суспенз.

Заалт:

Томуугийн А болон В хүрээний вирусээр үүсгэгдсэн томуугийн халдвараас урьдчилан сэргийлж 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст хэрэглэнэ.

Тун ба тарих арга:

Вакциныг гарын бугалганы (делтойд булчин) булчинд тарьж хэрэглэнэ.

- 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст: 0.5мл-ээр нэг удаа тарина.

Эсрэг заалт: Вакцинжуулахын өмнө тухайн хүнээс асуумж авч, бодит үзлэг хийнэ. Үзлэгээр дараах эмгэгийн аль нэг нь илэрсэн тохиолдолд вакцинжуулахыг зөвлөхгүй.

- Цочмог халдвар, архаг өвчний сэдрэлийн үе;
- Вакцины найрлагад орсон бодист анафилаксийн урвал илэрч байсан өгүүлэмжтэй;
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт, саажилтын хам шинж илэрсэн;
- Мэдрэлийн үрэвслийн хамшинжийн үе;
- Харшил, багтраа өвчтэй хүн;
- Дархлал дутмагшилтай хүн;

- Дааврын эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүн;
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэсэнээс хойш 6 долоо хоногийн дотор Гиллен-Барын хам шинж илэрч байсан эсвэл мэдрэлийн эмгэгтэй хүн;
- Хавдрын эмчилгээний цитостатик эм хэрэглэж байгаа бол.

Дархлаажуулалтын дараа илрэх урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын урвалын шинж илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд: Толгой эргэх, цочмог ханиах, архаг ринит, хоолой өвдөх, залгиурын үрэвсэл, хамрын салст бүрхэвчийн үрэвсэл илэрч болно.
- Маш цөөн тохиолдолд: Бөөлжих, суулгах, дотор муухайрах, чонон хөрвөс гарах, анафилаксын шок, энцефаломиелит, татах, мэдрэлийн өөрчлөлтүүд 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэгүүд илэрвэл эмч, эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, эмчийн зааврын дагуу эмчилгээг хийх хэрэгтэй.

Анхааруулга:

- Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна.
- Томуугийн вакциныг товлолын бусад вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна.
- Бусад вакцинтай 28 хоногийн завсартайгаар хийнэ.
- Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- Задалсан вакциныг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
 - Вакциныг +2- +8 хэмд хадгалсан;
 - Вакцины шошгоны бичиг арилаагүй;
 - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- Тарилга хийсэн хэсэг газрыг бохирдуулахгүй, цэвэр байлгах, ус хүргэхгүй, цохихгүй, маажихгүй байх талаар зөвлөнө. Мөн дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд эмчид яаралтай хандахыг вакцин хийлгэж байгаа хүнд зөвлөнө.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд:

Вакцин хийхийн өмнө жирэмсэн болон хөхүүл эмэгтэйг эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний 14-өөс 36 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд томуугийн вакцин хийж болно.

Хадгалалт, тээвэрлэлт, савлагаа

- Вакциныг +2-+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана
- Хөлдөөж болохгүй.
- Нэг хүн тун нь 0,5мл, нэг флаконд 10 хүн тунгаар буюу 5 мл-ээр савлагдсан.

Хүчинтэй хугацаа: 2023 оны 8 дугаар сар

Үйлдвэрлэгч: Грийн кросс корпораци, БНСУ

БНСУ-ЫН ГРИЙН КРОСС ҮЙЛДВЭРИЙН УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ "GC FLU" ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Улирлын томуугийн эсрэг "GCFLU" вакцин нь 2022/2023 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн вирусийн эсрэгтөрөгчийг идэвхгүйжүүлж гаргаж авсан, ДЭМБ-ын итгэмжлэл авсан вакцин юм. Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дэд хэвшинжийн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Найрлага:

Томуугийн вирусийн гурван дэд хэвшинжийг агуулсан.

А хүрээний Victoria/2570/2019IVR-215(H1N1)

А хүрээний Cambodia/e0826360/2020 IVR-224(H3N2)

В хүрээний Washington/02/2019

Нэмэлтээр тиомерсал, натри, калийн хлорид, гидрофосфат натри, калийн дигидроген фосфат, тарилгын ус агуулна.

Савлагаа:

Нэг хүн тун нь 0.5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Өнгөгүй, шингэн суспенз.

Тун ба тарих арга:

Вакциныг булчинд тарина.

- 6 сараас 2 настай (35 сар буюу 2 нас 11 сар 29 хоног) хүүхдэд 0.25 мл-ээр нэг удаа тарина.
- 3 ба түүнээс дээш настай хүнд 0.5 мл-ээр нэг удаа тарина.

Эсрэг заалт:

- Цочмог халдвар, архаг өвчний сэдрэлийн үе;
- Вакцины найрлагад орсон бодист анафилаксийн урвал илэрч байсан өгүүлэмжтэй;
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт, саажилтын хам шинж илэрсэн;
- Мэдрэлийн үрэвслийн хамшинжийн үе;
- Харшил, багтраа өвчтэй хүн;
- Дархлал дутмагшилтай хүн;
- Дааврын эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүн;
- Хавдарын эмчилгээний цитостатик эм хэрэглэж байгаа бол.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын урвалын шинж илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвал, татах, мэдрэлийн тогтолцооны ерөнхий болон хэсэг газрын үрэвсэл, амьсгалахад саадтай болох хүнд урвалууд вакцин хийлгэсний дараа 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэгүүд илэрвэл эмч,

эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, эмчийн зааврын дагуу эмчилгээг хийх хэрэгтэй.

Анхааруулга:

- Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна.
- Томуугийн вакциныг товлолын бусад вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна.
- Бусад вакцинтай 28 хоногийн завсартайгаар хийнэ.
- Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- Задалсан вакциныг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
 - Вакциныг +2- +8 хэмд хадгалсан;
 - Вакцины шошгоны бичиг арилаагүй;
 - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- Тарилга хийсэн хэсгийг бохирдуулахгүй байх, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд эмчид яаралтай хандахыг вакцин хийлгэж байгаа хүнд зөвлөнө.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд

Вакцин хийхийн өмнө жирэмсэн болон хөхүүл эмэгтэйг эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний 14-өөс 36 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд томуугийн вакцин хийж болно.

Хадгалах тээвэрлэх:

- Вакциныг +2-+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянан.
- Хөлдөөж болохгүй.

Хүчинтэй хугацаа: 2023 оны 6 дугаар сар

Үйлдвэрлэгч: Грийн кросс корпораци, БНСУ

--oOo--

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 сарын 19-ны өдрийн А/512 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



**УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИН ХИЙХЭД ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ,
АСРАН ХАМГААЛАГЧААС АВАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС**

Миний хүү/охин овогтойнь
..... настай.дүүргийн хороонысургууль, цэцэрлэгт суралцдаг.
Эцэг эх асран хамгаалагч Би хүүхдэдээ улирлын томуугийн вакцин хийлгэхийг зөвшөөрч байна.
Улирлын томуугийн эсрэг вакцины зааврыг уншиж, танилцсан болно.
Гарын үсэг: эцэг/ эх / асран хамгаалагч
Огноо: 2022 оны дугаар сарын өдөр

Томуугийн вакцины талаарх мэдээлэл

Тайлбар: Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулахаас өмнө энэхүү зөвшөөрлийн хуудсыг ангийн багш хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид заавал танилцуулж, гарын үсэг авсан байна. Сүүлийн нэг сарын хугацаанд товлолын болон сайн дураар томуугийн вакцинд хамрагдаагүй байх